

ТӨСӨЛ

## ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

### Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.3.6 дахь заалт, 79.7 дахь хэсэг, 271<sup>1</sup> дүгээр зүйлийн 271<sup>1</sup>.1.2 дахь заалт, Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын ...-ны өдрийн хуралдааны ..../.... дугаартай шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Гаалийн ерөнхий газрын даргын 2008 оны Журам батлах тухай 678 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Гаалийн тусгай бүсийн горим хэрэгжүүлэх журам”-ын 6.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“6.1.Гаалийн тусгай бүс байгуулах хуулийн этгээд нь гаалийн тусгай бүс байгуулах зөвшөөрөл авах хүсэлт, Гаалийн тухай хуулийн 139 дүгээр зүйлд заасан бичиг баримтыг бүрдүүлэн цахимаар ирүүлнэ.

2.Энэхүү журмын 4.13 дахь заалтыг хассугай.

3.Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гаалийн хяналт, шалгалтын газар /Б.Даваасүрэн/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.АСРАЛТ